

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 03 дугаар сарын 15

Дугаар 62

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах  
санал уламжлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/530 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай 12/36 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтын Баянзүрх дүүрэгт холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах саналыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.

2.Хороо хувааж шинээр байгуулагдсан хороодыг нэгдүгээр, хилийн заагт өөрчлөлт орсон хороодыг хоёрдугаар хавсралтад зааснаар өөрчлөлт оруулахаар санал хүргүүлсүгэй.

3.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай саналыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлан шийдвэрлүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Баярмөнх)-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны  
03 дугаар сарын .....-ны өдрийн  
аравдугаар хуралдааны .... дугаар  
тогтоолын нэгдүгээр хавсралт

### ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН ХОРООДЫН ЖАГСААЛТ

Д/д	Хуваах хороод	Шинээр байгуулагдах хороод
1	2, 21, 27 дугаар хороо	29 дүгээр хороо
2	2, 4, 5, 27 дугаар хороо	30 дугаар хороо
3	5 дугаар хороо	31 дүгээр хороо
		41 дүгээр хороо
4	22 дугаар хороо	32 дугаар хороо
5	20 дугаар хороо	33 дугаар хороо
6	9 дүгээр хороо	34 дүгээр хороо
7	20, 23 дугаар хороо	35 дугаар хороо
8	26 дугаар хороо	36 дугаар хороо
9	12 дугаар хороо	37 дугаар хороо
10	8 дугаар хороо	38 дугаар хороо
		39 дүгээр хороо
11	16 дугаар хороо	40 дүгээр хороо
12	14 дүгээр хороо	42 дугаар хороо
13	25 дугаар хороо	43 дугаар хороо

Баянзүрх дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03  
дугаар сарын .....-ны өдрийн  
аравдугаар хуралдааны .... дугаар  
тогтоолын хоёрдугаар хавсралт

### ХИЛИЙН ЗААГТ ӨӨРЧЛӨЛТ ОРОХ ХОРООД

<b>Д/д</b>	<b>Баянзүрх дүүрэг</b>
1	1 дүгээр хороо
2	2 дугаар хороо
3	3 дугаар хороо
4	4 дүгээр хороо
5	5 дугаар хороо
6	7 дугаар хороо
7	8 дугаар хороо
8	9 дүгээр хороо
9	10 дугаар хороо
10	11 дүгээр хороо
11	12 дугаар хороо
12	14 дүгээр хороо
13	16 дугаар хороо
14	17 дугаар хороо
15	18 дугаар хороо
16	19 дүгээр хороо
17	20 дугаар хороо
18	21 дүгээр хороо
19	22 дугаар хороо
20	23 дугаар хороо
21	25 дугаар хороо
22	26 дугаар хороо
23	27 дугаар хороо
24	28 дугаар хороо
Нийт	24 хороо